

Аврахаам эцэг

3-р хичээл

Аврахаамын амьдрал:
Орчин үеийн хэрэгжүүлэлт
(Пентатекийн 8-р хичээл)

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ ©1990 Эхлэл, номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан.

Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 онд ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАРУУДАД ЧИГЛЭДЭГ:

БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ. БҮХ ДЭЛХИЙД. ҮНЭГҮЙ.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

Аврахаам эцэг

Гуравдугаар хичээл

Аврахаамын амьдрал: Орчин үеийн хэрэгжүүлэлт

Гарчиг

Удиртгал	1
Аврахаам ба Есүс	2
Аврахаамын үр хүүхэд	2
цор ганц.....	3
Христ бол тэр үр удам мөн	5
Гол сэдвүүд.....	7
Ертөнцийн Эзэний хайр өршөөл	7
Аврахаамын үнэнч байдал	8
Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс	8
Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс	9
Израильчууд ба Христийн сүм	10
Аврахаамын үр удам.....	11
тооны хувьд хамрах хүрээ.....	11
угсаатны хувьд ялгарах шинж	12
сүнсний мөн чанар	13
түүхэн нөхцөл байдал.....	15
Гол сэдвүүд.....	17
Ертөнцийн Эзэний хайр өршөөл	17
Аврахаамын үнэнч байдал	17
Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс	18
Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс	19
ДҮГНЭЛТ.....	19
ҮГСИЙН ТАЙЛБАР	21

Аврахаам эцэг

Гуравдугаар хичээл

Аврахаамын амьдрал: Орчин үеийн хэрэгжүүлэлт

УДИРТГАЛ

Орчин үеийн олон хүн Библийн талаар нэг л бэршээлтэй тулгарч болох юм. Энэ нь юу гээч? Тэдэнд олон мянган жилийн өмнө бичсэн түүх өнөөгийн бидний амьдралыг удирдан чиглүүлэх чадвартай гэж төсөөлөх л хэцүү байдаг ажээ. Ийм бодол Библид буй Аврахаамын амьдралын тухай тэмдэглэлийн хувьд яриангүй үнэн байдаг юм. Аврахаам өөрөө бол 4000 гаруй жилийн өмнө амьдарч байсан билээ. Түүний тухай түүхийг 3600 гаруй жилийн өмнө бичсэн байдаг. Харин Христийн дагалдагч бид бүхэн эдгээр түүх бол Ертөнцийн Эзэний сургаалийн нэг хэсэг учраас орчин үеийн хүмүүсийн амьдралд ч гэсэн ашиг тусаа өгнө гэдэгт бүрэн итгэдэг юм.

Гэхдээ бид үүнд бат итгэдэг ч гэсэн зарим нэг асуулт хариултаа нэхсээр л байдаг. «Аврахаамын тухай эдгээр түүх нь өнөөгийн бидний амьдралд хэрхэн хэрэгжих вэ? Өөрсдийг маань Аврахаамаас тусгаарлаж буй энэ 4000 жилийн хоосон зайг бид хэрхэн дүүргэх вэ? гэх мэтийн олон асуулт байна.

Бид Эхлэл номонд гарах Аврахаамын амьдралыг судлаж байгаа учраа энэ цуврал хичээлээ «Аврахаам эцэг» гэж нэрлэсэн билээ. Энэ бол дээрх гурван танилцуулга хичээлийн гуравдахь нь юм. Бид үүнийг “Аврахаамын амьдрал: Орчин үеийн хэрэгжүүлэлт” гэж нэрлэлээ. Бид энэ хичээлээр Аврахаамын тухай өгүүлсэн Эхлэл номын бүлгүүдээс түүний амьдралыг орчин үед хэрхэн үнэн зөв хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулж дүгнэлт гаргах болно. Ер нь бид Аврахаамын тухай түүхийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ? Эдгээр нь өнөө үед бидэнд ямар байдлаар нөлөө үзүүлж байна вэ?

Аврахаамын амьдралыг өнөөгийн бидний энэ дэлхий ертөнцдөө хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгохын тулд бид 2 үндсэн чиглэлээр судлах болно: Бид эхлээд Аврахаам ба Есүсийн хооронд буй холбоог судлана. Хоёрдугаарт, анхны уншигч болсон Израйльчууд ба өнөөгийн уншигчид болох Христийн сүмийн хооронд буй холбоог ч бас судлах юм.

Аврахаамын амьдралыг орчин үед хэрэгжүүлэх талаар судлахаасаа өмнө бид өмнөх хичээлүүдээр үзсэн бүхнээ дахин нэг тоймлож үзэх хэрэгтэй байх. Бид Аврахаамын амьдрал нь таван тэгш хэмт буюу тэнцвэртэй үе шатаас бүрдэж байгааг үзсэн. Эхнийх нь, 11-р бүлгийн 10-аас 12-р бүлгийн 9-д гарч буй Аврахаамын уг гарал болон Ертөнцийн Эзэнтэй харилцсан анхны харилцааг өгүүлдэг. Хоёрдахь нь, 12-р бүлгийн 10-аас 14-р бүлгийн 24-т гарах хэдэн үйл явдал бөгөөд энэ нь бусад хүмүүстэй харилцсан Аврахаамын эхний харилцаан дээр төвлөрдөг. Гуравдахь нь буюу Аврахаамын амьдралын гол хэсэг түүнтэй байгуулсан Ертөнцийн Эзэний гэрээнд төвлөрч байгааг 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-д бичжээ. Аврахаамын амьдралын дөрөвдөхь шат бол түүний бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцаа бөгөөд энэ тухай 18-р бүлгийн 1-ээс 21-р бүлгийн 34-д бичсэн байдаг. Харин тавдахь шат нь Аврахаамын бусад үр хүүхэд ба үхлийн тухай өгүүлсэн хэсэг бөгөөд үүнийг 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18-д бичсэн байдаг. Энэ 5 шат нь энэ алдарт өвгийн амьдралыг тэгш хэмт байдлаар танилцуулдаг. 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-г

хамарсан гуравдахь хэсэг нь Аврахаамтай тогтоосон Ертөнцийн Эзэний гэрээний тухай өгүүлдэг бөгөөд түүний амьдралын хамгийн гол хэсэг болж ордог юм. Тэгвэл хоёрдахь болон дөрөвдэхь хэсгүүд нь бусад хүнтэй харилцсан Аврахаамын харилцаан дээр гол анхаарлаа хандуулж, үүгээрээ бие биенээ харьцуулсан байдаг. Харин эхний болон сүүлчийн хэсэг нь Аврахаамын гэр бүлийн өнгөрсөн болон ирээдүйг мөшгөж, түүний амьдралын эхлэл төгсгөлийг өгүүлсэнээрээ хоорондоо төстэй байдаг юм. Бид өмнөх хичээлүүдэд Аврахаамын амьдралын үндсэн бүтцээс гадна түүний тухай Мөшэх бичихдээ зорилго агуулж байсан гэдгийг үзсэн билээ. Мөшэх Израйльчуудад Египет орныг яагаад орхин гарч байгааг, хэрхэн тэндээс явж Ертөнцийн Эзэний амласан нутгийг эзлэн авахыг заахын тулд Аврахаамын тухай бичсэн юм. Өөрөөр хэлбэл, Мөшэхийг дагаж буй Израйльчууд Аврахаамаас өөрсдийнхөө түүхэн нөхцөл байдлыг харж, түүний түүхээс даган дуурайх эсвэл татгалзан үгүйсгэх үлгэр дууриал жишээг олж, хэрхэн түүний амьдрал өөрсдөд нь тохиолдох зүйлсийн урьдчилсан дохио болж байгааг гярхай ажигласнаар тэдэнд зориулсан Ертөнцийн Эзэн зорилгыг биелүүлэхээр зүтгэх арга замаа мэдэж авч болох байлаа. Бид энэ бүхнийг сэтгэлдээ тунгаан бодоод Аврахаамын амьдралын түүхийг орчин үед хэрхэн хэрэгжүүлэх талаар үзэхэд бэлэн боллоо.

ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

За одоо бүгдээрээ Аврахаам ба Есүсийн хоорондын холбоог судалцаая. Харамсалтай нь Христэд итгэгчид олон удаа Аврахаамын амьдралын түүхийг орчин үеийн амьдралдаа шууд л бүдүүн бараг байдлаар хэрэглэдэг. Бид Аврахаамын түүхэнд өөрсдийн маань амьдралд шууд хандсан хэлсэн ёс суртахууны энгийн түүх мэтээр ханддаг. Гэхдээ Христэд итгэдгийнхээ хувьд бид Аврахаамтай харилцах бидний харилцааг Есүс зуучлан тогтоосон гэдгийг мэднэ. Бид Аврахаамын онцгой үр хүүхэд болох Христтэй нэгдсэн учраас түүний амьдрал бидэнтэй холбоотой байдаг. Аврахаам болон бидний хооронд Христ зогсож байдаг. Ийм л шалтгааны улмаас бид Аврахаамын тухай өгүүлсэн Библийн түүхүүдийг үргэлж Христ болон Түүний хийсэн бүхнийг үндэс болгон авч үзэж байх хэрэгтэй.

Израйлийн алдартай энэ өвөг ба Христ хоёрын хоорондын холбоог ойлгохын тулд бид 2 асуудлыг хөндөнө. Нэг талаар бид, Шинэ Гэрээ хэрхэн Христ бол Аврахаамын үр удам мөн гэж зааж байгааг судлах болно. Нөгөө талаар Аврахаамын амьдралаас бидний ажигласан дөрвөн гол сэдэв нь түүний үр удам болох Христэд хэрхэн хэрэгжиж байгаа үзнэ. За эхлээд бүгдээрээ Есүс бол Аврахаамын үр удам гэсэн ойлголтыг авч үзэцгээе.

АВРАХААМЫН ҮР УДАМ

Аврахаам бол эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдүүд гээд хүн төрөлхтөний түүхийн турш амьдарч байсан бүх итгэгчийн эцэг гэдэг ойлголт байдаг нь үнэний хувьтай.

Бид бүгд түүний гэр бүл, үр хүүхэд, өв залгамжлагчдын нэг билээ. Харин бид Аврахаамын онцгой үр удам болох Христтэй нэгдсэн учраас ийм байр суурийг эзэлдэг гэдгийг Шинэ Гэрээ улам тодорхой болгож байгааг бид үзэх болно. Бид Ертөнцийн Эзэний сургаалд ийм үзэл бодлыг хэрхэн зааж байгааг ойлгохын тулд 2 асуудлыг тун товчхон хөндөнө. Эхлээд бид энд гарах үр удам гэдэг ойлголт нь цор ганц болох тухай үзнэ. Хоёрдугаарт, Христ бол Аврахаамын хосгүй үр хүүхэд мөн гэдэг ойлголтыг авч үзнэ.

цор ганц

Эхлээд бүгдээрээ Аврахаамын цорын ганц үр хүүхэд гэдэг ойлголтонд Библи хэрхэн анхаарч байгааг бодож үзэцгээе. Үүнтэй холбоотой хамгийн чухал ишлэл бол Галатын 3-ийн 16 байх аа. Тэр ишлэлд:

Аврахаам ба түүний үе удамд онцгой сайн юм хийж өгөхөө Ертөнцийн Эзэн амласан байна. Тэгэхдээ 'Би чамд өөрт чинь болон танайхны олон үе удамд онцгой сайн үйлс бүтээж өгөх болно' гээгүй, харин 'Би чамд өөрт чинь болон чиний нэгэн удамд онцгой сайн үйлс бүтээж өгнө' хэмээн амлажээ. Тэр нэг удам нь Есүс Христ байлаа (Галат 3:16).

Эхлэл номонд Ертөнцийн Эзэн Аврахаам болон түүний үр удам буюу үр хүүхдэд нь амлалт өгсөн баримтыг Пууль энэ хэсэгт дурдсан байна. Пууль энд 'үр удам' гэдэг үгийг хэрхэн онцгойлон анхаарч, Аврахаам болон түүний үр удам буюу үй олон хүнд Ертөнцийн Эзэн нэгэн онцгой сайн юм хийж өгнө гэж амлаагүй, харин түүнд болон түүний нэг удам болох Христ хэмээх ганц л хүнд тэр онцгой сайн юмыг хийх өгөхөөр амласан гэж хэлснийг анзаарах хэрэгтэй.

Пууль энд 'үр удам' гэж орчуулсан Еврей хэлний 'зерах' гэдэг үг нь ганц тоог заасан байдгийг хэлж байр сууриа нотолсон. Мөн Пуулийн үед нилээд олдоцтой байсан Хуучин Гэрээний Грек орчуулгад орсон 'сперма' гэдэг үг ч гэсэн ийм утгатай байсан. Яг л Пуулийн хэлсэнчлэн Ертөнцийн Эзэн амлалтаа Аврахаамын нэг л үр удамд гэж ганц тоон дээр хэлсэн болохоос Аврахаам болон түүний үр удмууд гэж олон тоон дээр хэлээгүй юм.

Өнгөц харахад Пуулийн хэлэх гэсэн санаа илэн далангүй байгаа мэт санагддаг. Аврахаамын өв зөвхөн ганцхан үр удамд нь буюу хойч үеийн нэг л хүнд очих ажээ. Яагаад гэвэл энэ үг нь ганц тоон дээр байна. Гэвч 'үр удам' гэдэг үг нь ганц хүнийг хэлж байна гэж үзсэн Пуулийн нотолгоо нь Библийн тайлбарлагчдад янз бүрийн бэрхшээлтэй асуудлыг гаргаж ирэхэд хүргэжээ. Нэг иймэрхүү бэрхшээлтэй асуудал гарч ирсэн байна. 'Зерах' буюу 'үр удам' гэдэг үг нь ганц тоог заадаг нь үнэн. Гэхдээ Аврахаамын амьдралын түүхийг оруулаад Хуучин Гэрээний олон хэсэгт энэ 'үр удам' гэдэг үг нь ганц тоон дээр байдаг ч бүлэг хүнийг заасан утгатай нийлмэл ганц тооны хэлбэрээр ордог юм. Еврей хэлний энэ 'зерах' буюу 'үр удам' гэдэг үг нь Англи хэлний 'үр сад' гэдэг үгтэй их адилхан байдаг. Хэдийгээр энэ үг нь хэлбэрийн хувьд ганц тоон дээр байдаг ч энэ нь нэг үр сад, удам угсааг эсвэл олон үр сад, удам угсааг хэлж болдог.”

Жишээлбэл, энэ 'зерах' буюу 'үр удам' гэдэг үг нь Эхлэлийн 15-ийн 13-д яах аргагүй олон тоог заасан утгаар ордог. Тэнд Ертөнцийн Эзэн Аврахаамд хандан.

Чиний удам угсаа хожим өөрсдийн бус харь оронд очоод дөрвөн зуун жилийн турш тэнд боолчлогдон дарлагдах боловч тэднийг дарлагч тэр үндэстнийг нь би асар хүндээр шийтгэнэ (Эхлэл 15:13).

Энд гарч буй 'удам угсаа' гэдэг үг бол нөгөө ганц тоог заасан 'зерах' гэдэг Еврей үг бөгөөд олон тоог заасан утгаар орсон нь илэрхий байна. Энэ ишлэлд бичсэнээр удам угсаа нь 'өөрсдийн бус' хэмээн олон тоон дээр, мөн 'боолчлогдон дарлагдах боловч тэднийг' хэмээн үйл үг нь хүртэл Еврей хэлэндээ олон тоон дээр байдаг.

Мэдээж 'үр удам' гэсэн энэ ганц тоон дээр байгаа үг нь Эхлэл номонд нэгээс илүү олон хүнийг заасан утгаар олонтоо орсон гэдгийг Пууль мэдэж байсан. Үнэнийг хэлэхэд Пууль өөрөө хүртэл энэ 'үр удам' гэдэг үгийг Галатын 3-ийн 29-д олон тоог заасан утгаар,

Та нар . . . Аврахаамын удам болсон. Мөн түүнд Ертөнцийн Эзэний амласан зүйлийг хүлээн авах өв залгамжлагчид болсон юм (Галат 3:29).

Энэ ишлэлд буй 'Та нар . . . болсон' гэдэг хэсгийн үйл үг нь Грек хэлний олон тоог заасан 'эсте' гэдэг үгийн орчуулга юм. Харин Аврахаамын 'үр удам' гэдэг үг нь 'өв залгамжлагч' гэдэг үгтэй ойролцоо утгатай бөгөөд Грек хэлний 'тераномой' хэмээх мөн л олон тоонд хэрэглэдэг үг ажээ.

Эдгээр харгалзан үзвэл, бид нэг асуулт асуух хэрэгтэй болж байна.

Хэрэв Пууль 'үр удам' гэдэг үгийн ганц тооны хэлбэр нь нэгээс ч олон хүнийг заадаг гэдгийг мэдэж байсан юм бол яагаад үүний ганц тооны хэлбэрийг нь чухалчилсан юм бол? Ер нь Аврахаамын амьдралын тухайд Пуулийн сэтгэлээс гарахгүй байсан ганц хэсэг бол Эхлэлийн 22-р бүлгийн 16-аас 18 хүртэлх ишлэлүүд болов уу. Эдгээр ишлэлд энэ 'үр удам' гэдэг үг нь яах аргагүй ганц тооны утгаар орсон байдаг. Энэ үгчилсэн орчуулгыг сонс доо:

Мөнхийн Эзэн дараах үгийг чамд хэлж байна. 'Би одоо чамд өөрийн нэрээр тангараглана. Чи хайртай ганц хүүгээ надад харамгүй өргөхөд бэлэн байсан учраас би чамд хайр ивээлээ харуулж ажил үйлсийг чинь бүтэмжтэй, аз жаргалтай болгож өгөхөө амлая! . . . Чиний тэр удам дайснаа дарж газар нутгийг нь эзлэн авна. Чи миний үгийг бат дагасан учраас одоо чиний удмаар дамжин үндэстэн бүхэн миний хайр ивээлийг харах болно (Эхлэл 22:16-18, Үгчилсэн орчуулга).

Харамсалтай нь орчин үеийн олон орчуулганд энэ хэсгийг олон хүнийг заасан ганц тооны хэлбэрээр орчуулсан байдаг. Гэхдээ энэ нь Яйцхаахыг өргөл болгон өргөх гэж оролдсон үйл явдлын нэг хэсэг учраас энд гарч буй 'үр удам' гэдэг үг нь Аврахаамын удам угсааг ерөнхийд нь хэлээгүй, харин түүний хүү Яйцхаахыг л хэлсэн юм. 'Эзлэн

авна' гэдэг үйл үг нь Еврей хэлэнд ганц тоог заасан байдаг. Мөн 'дайснаа' гэдэг үг нь ганц тоог зааж байгааг анзаарах хэрэгтэй.

Бид Эхлэлийн 22 болон удаах бүлгүүдээс Сараахын хүү Яйцхаахыг Аврахаамын бусад эхнэр болох Хагаар болон Хитуурахын хүүхдүүдээс ялган тусгаарлахад нилээд их хугацаа зарцуулж байгааг хардаг. Яйцхаах бол Аврахаамын цорын ганц хүү байхаар Ертөнцийн Эзэний онцгойлон сонгож түүнд амласан тусгай хүүхэд билээ. Тийм учраас Эхлэл номонд Яйцхаахыг төрөхөөс өмнө Аврахаамын үр удмын тухай өгүүлэхдээ ихэвчлэн 'үр сад' хэмээн бүлэг хүнийг заасан утгаар хэлдэг байжээ. Харин энд энэ үг нь Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний амлалтыг өвлөн авах цорын ганц онцгой удам болох Яйцхаахад гол анхаарлаа хандуулсан байна.

Үүнийг харгалзан үзсэн цагтаа л Аврахаамын ганц үр удмын тухай дурдахдаа Пууль ямар санаатай байсныг бид ойлгож чадна. Эхлэлийн 22-р бүлэгт Ертөнцийн Эзэн шууд л Аврахаам болон түүний бүх удам угсаанд амлалтаа өгөөгүй гэдгийг Пууль ажигласан байна. Тэрбээр Эхлэлийн 22-р бүлгийн 16-аас 18-д гарч буй 'үр удам' гэдэг үг ганц тоон дээр байгаа нь Ертөнцийн Эзэний амлалт нь Аврахаамын онцгой хүү, өв залгамжлагч Яйцхаахад дамжин ирэхийг заасан болохыг хэлсэн байдаг.

Христ бол тэр үр удам мөн

Ийнхүү бид Аврахаамын үр удам гэдэг ойлголт нь ганц тоон дээр байгаа гэдгийг сэтгэлдээ тээнгээ Христ бол Аврахаамын үр удам болох тухай хичээлдээ орцгооё. Бүгдээрээ Есүсийн төлөөлөгч Пууль Галатын 3-ийн 16-д юу гэж хэлснийг дахин нэг сонсьё:

Аврахаам ба түүний үе удамд онцгой сайн юм хийж өгөхөө Ертөнцийн Эзэн амласан байна. Тэгэхдээ 'Би чамд өөрт чинь болон танайхны олон үе удамд онцгой сайн үйлс бүтээж өгөх болно' гээгүй харин 'Би чамд өөрт чинь болон чиний нэгэн удамд онцгой сайн үйлс бүтээж өгнө' хэмээн амлажээ. Тэр нэг удам нь Есүс Христ байлаа (Галат 3:16).

Энд Пууль зөвхөн 'үр удам' гэдэг үг нь ганц тоон дээр байхаас гадна тэр нь Аврахаамын цорын ганц удам болох Христ мөн гэдэг баримтанд анхаарлаа хандуулж байна. Тэгэхлээр Эхлэлийн эх утгаас харахад Аврахаамын цорын ганц удам гэж Мөшэхийн бичсэн хүн бол Сараахаас төрсөн нөгөө амлалтын онцгой хүү Яйцхаахаас өөр хэн ч биш гэж өмнө нь бид үзсэн. Тэгвэл Аврахаамын цорын ганц үр удам бол Есүс мөн гэж Пуулийн бичснийг бид юу гэж ойлгох вэ?

Аврахаамын өв бол түүний үр садад хамаатай гэр бүлийн өв гэдгийг мартаж болохгүй. Библид гарч буй түүхийн хэд хэдэн эгцэгтэй мөчид Аврахаамын өвийг хүлээн аваад бусдад түгээх онцгой өв залгамжлагч болох хүмүүсийг Ертөнцийн Эзэн сонгож байлаа. Яйцхаах бол Аврахаамын бусад хүүхдээс ялгаатай, түүний онцгой үр удам байв. Ертөнцийн Эзэн Яйцхаахыг хоёр хүүхэдтэй болсоны дараа хүү Яаховыг нь Аврахаамын тусгай үр удам болгон сонгон аваад нөгөө хүү Исаав болон түүний

удам угсааг энэ сонголтоос хасдаг. Харин Яаховын 12 хүү нь Израйлийн 12 овог аймгийн тэргүүн болдог. Израйлийн эдгээр овог аймгаас хэдэн хүн л Аврахаамын онцгой үр удам болон сонгогддог. Жишээ нь, Ертөнцийн Эзэний ард түмнийг Египетээс удирдан Амласан нутаг руу дагуулан явсан удирдагч бөгөөд зуучлагч нь Мөшэх байна. Хожим Израйль нь бүрэн эрхт улс болоход Давид болон түүний хүүхдүүд Аврахаамын өвийг зуучлан дамжуулах тусгай үүргийг гүйцэтгэж байлаа.

Давид болон түүний хүүхдүүдийн гүйцэтгэж байсан энэ тусгай үүрэг роль л Пуулийг Христ бол Аврахаамын хамгийн сүүлчийн агуу үр удам гэж хэлэхэд хүргэсэн юм. Учир нь Есүс бол Давидын хаан ширээг залгамжлах хууль ёсны өв залгамжлагч нь байсан билээ. Ертөнцийн Эзэн түүнийг Өөрийнхөө ард түмний үүрдийн хаан байлгахар сонгосон юм. Тэрбээр Аврахаамын агуу, мөнхөд орших, хаан угсааны удам, мөн Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагч байсан билээ. Тиймээс хүн зөвхөн Христээр л дамжин Аврахаамын өвийг хүлээн авах боломжтой ажээ. Христээс салсан хэн боловч Аврахаамд өгсөн амлалтыг хүлээн авахгүй.

Тэгэхлээр бид Есүсийг Аврахаамтай холбож нэг иймэрхүү байдлаар дүгнэж болно. Христийнхэний үзлээр бол Есүс нь Аврахаамын хосгүй бөгөөд эцсийн үр удам нь юм. Христэд итгэгчдийнхээ хувьд бид Аврахаамын амьдралыг өнөөгийн амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсвэл Аврахаам болон бидний одоогийн ертөнцийн хоорондын холбоог цаг үргэлж бодож байх хэрэгтэй. Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний агуу ивээлүүд нь Христ хаант улсаа байгуулж, одоо үргэлжлүүлж, улмаар ирээдүйд бүрэн төгсгөх хүртэл Христээр дамжин бидэнд ирдэг юм.

Христ Аврахаамын өвийг 3 үе шаттай хүлээн авч тараадаг гэж Шинэ Гэрээ заадаг. Эхнийх нь Христийг анх ирэхэд үед Түүний хаант улс байгуулагдаж эхэлсэн үе юм. Хоёрдахь нь, Есүсийг анх ирсэнээс эхлээд ирээдүйд дахин ирэх хүртэл хүн төрөлхтний бүх түүхийг хамрах орших Түүний хаант улсын үргэлжлэл юм. Харин гуравдахь нь, Есүсийг сүр жавхлантайгаар эргэн ирэх үед болох Түүний хаант улсын төгсгөлийн үе шат юм. Тэрбээр Ертөнцийн Эзэн Эцгийнхээ баруун гар талд заларч бүгдийг захирч байхдаа Аврахаамын өвийг улам ихээр өвлөн бусдад тараах ажлаа үргэлжлүүлсээр байна. Тэгээд нэгэн өдөр л яруу алдраа дуурсган энэ дэлхийд эргэн ирэхдээ Аврахаамын өвийг бүрэн хүлээн авч бүгдийг тараах болно.

Нэг үгээр хэлбэл, Пууль Галатын 3-р бүлгийн 16-д теологийн нилээд төвөгтэй үзэл бодлыг хураангуйлан хэлсэн гэдгийг ойлгох нь тун чухал юм шүү. Ийнхүү Пууль Ертөнцийн Эзэний амлалт нь Аврахаам болон түүний ганц үр удамд хамаатай бөгөөд тэр үр удмыг Христтэй адилтгахдаа Эхлэл номонд гарсан тэр 'үр удам' гэдэг үг нь шууд Есүсийг хэлж байгаа юм гэж хэлээгүй. Үүний оронд Яйцхаах Есүс хоёрын хооронд оршин байсан хэв шинжит дүрийг л товчлон хэлсэн хэрэг шүү дээ. Үүнийг илүү тодорхой болгохын тулд ингэж хэлж болно. Тухайн үедээ Яйцхаах нь Аврахаамын гол өв залгамжлагч байсан шиг Христ бол Шинэ Гэрээний үед Аврахаамын хамгийн агуу хүү бөгөөд гол өв залгамжлагч нь болсон юм.

ГОЛ СЭДВҮҮД

Христ бол Аврахаамын үр удам гэдэг ойлголтын утгыг бүрэн ойлгоход

Аврахаамын түүхээс бидний харсан 4 гол сэдвийг үүнтэй холбож судлах нь тус болох болов уу. Бид Эхлэл номын дээрх бүлгүүдээс Ертөнцийн Эзэний хайр өршөөл, Аврахаамын үнэнч байдал, Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс, Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс гэсэн 4 гол сэдвийг үзэж байсныг та нар санаж байгаа байх. Тэгвэл бид эдгээр санааг Аврахаам болон Христийн хоорондын холбоотой холбож хэрхэн ойлгох вэ?

Ертөнцийн Эзэний хайр өршөөл

Юуны өмнө Ертөнцийн Эзэн Аврахаамын амьдрал хайр өршөөлөө илүү ихээр үзүүлж байгааг бид харсан. Мэдээж Аврахаам гэмт хүн учраас Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг хувьчлан хүртсэн нь үнэн. Гэхдээ үүнээс гадна Аврахаамд үзүүлж буй Ертөнцийн Эзэний өршөөл энэрэл нь Түүний сайхан сэтгэлийг бодитой харуулдаг билээ. Ертөнцийн Эзэн Аврахаамтай харилцаа тогтоосноороо үнэн хэрэгтээ хүн төрөлхтнийг бүхэлд нь аврах үйл хэргээ урагшлуулсан юм.

Хэдийгээр Ертөнцийн Эзэн сайхан сэтгэлээ Аврахаамын амьдралд илүү тод харуулсан ч гэсэн Аврахаамд хандсан Түүний хайр өршөөл нь Христэд харуулсан өршөөл энэрлийнх нь сүүдэр төдийг байсан гэдэгт Христэд итгэгч бид итгэдэг. Мэдээж Христ өөрөө ямар ч гэмгүй байсан учраас Ертөнцийн Эзэнээс авралын хайр өршөөлийг хүлээн аваагүй. Гэхдээ Христ Аврахаамын үр удам болж ирсэн нь хүн төрөлхтөнд үзүүлж буй Ертөнцийн Эзэний өршөөл энэрлийн асар том бодит үйл хэрэг болсон юм.

Ертөнцийн Эзэн Христийн эхний ирэлт буюу Түүнийг хаант улсаа байгуулж эхлэх үед өршөөл энэрлээ харамгүй ихээр үзүүлсэн байдаг. Христийн амьдрал, үхэл, дахин амилалт болон тэнгэрт одсон үйл явдал мөн Ариун Сүнсээр дүүрэн байсан зэрэг нь Ертөнцийн Эзэний хайр өршөөлийн гайхамшигтай илэрхийлэл байлаа. Христийг одоо ер бусын улсдаа залраад бүхнийг захирч байхад буюу Түүний хаант улс оршин тогтнож байгаа өнөө үед ч Ертөнцийн Эзэн өршөөл энэрлээ улам их үзүүлсээр байна. Ертөнцийн Эзэний аврал дэлхий даяар тарах бүр хүн төрөлхтний түүхийн туршид гарсан хэн ч үгүйсгэж чадахгүй хувирал өөрчлөлтөөр дамжин, Христэд үзүүлсэн Түүний сайхан сэтгэл улам бүр тод харагдсаар байна. За харин Христ энэ дэлхийд дахин ирэх үед буюу Түүний хаант улс бүрэн байгуулагдаж төгсөх үед Ертөнцийн Эзэн өршөөл энэрлээ хэмжээлшгүй ихээр үзүүлэх болно. Христ эргэж ирээд шинэ тэнгэр, шинэ дэлхийг бий болгоно.

Христийн дагалдагчийнхаа хувьд бид бүхэн Аврахаамын түүхээс Ертөнцийн Эзэн сайхан сэтгэлээ түүнд хэрхэн харуулж байсныг унших бүртээ зүрх сэтгэлээ, Түүний өршөөл энэрэл Христийн хаант улсын энэ гурван үе шат бүрд хэрхэн илрэн харагдаж байгаа явдалд хандуулж байх хэрэгтэй.

Аврахаамын үнэнч байдал

Хоёрдугаарт, Аврахаамын амьдралын талаар Мөшэхийн хийсэн

танилцуулгад гарах өөр нэг чухал сэдэв бол Аврахаамын Ертөнцийн Эзэнд хандсан үнэнч байдал юм. Эхэндээ Ертөнцийн Эзэн Аврахаамаас амласан нутаг руу нүүхийг үүрэг болгон, улмаар биелүүлэхийг шаардаж байв. Гэхдээ дараа нь Ертөнцийн Эзэн Аврахаамын амьдралын турш түүнээс өөр зүйлийг шаардаж байсан билээ. Бид Христэд итгэгч хүнийхээ хувьд Аврахаамын хүлээсэн үүрэг хариуцлагын талаар уншиж байхдаа зүрх сэтгэл санаа бодлоо Аврахаамын үр удам болох Христ болон Тэрбээр Ер бусын Эцэгтээ хэрхэн үнэнч байсан явдал руу хандуулж байх хэрэгтэй.

Мэдээж, Христ хаант улсынхаа 3 үе шат бүрт Ер бусын Эцэгтээ үнэнч байсан билээ. Христ Хаант улсаа байгуулж эхлэхдээ, үнэнч шударга байх Ертөнцийн Эзэний шаардлагыг Өөрөө биечлэн туйлын найдвартай биелүүлж нотолсон байдаг. Аврахаам амьдралынхаа маш чухал үеүдэд Ертөнцийн Эзэнд үнэнч байсан бол Христ амьдралынха мөч бүрд Ертөнцийн Эзэнд туйлын үнэнч байсан юм. Үүнээс гадна бүхнийг захирагч Хааны хувьд Христ Хаант улсынхаа үргэлжлэн тогтнож байгаа үед ч Ер бусын Эцэгтээ үнэнч хэвээр үлдсэн билээ. Тэрбээр Сайн мэдээг түгээн дэлгэрүүлж, Өөрийнхөө хүмүүсийг аварч байгаа үйл хэргээрээ бүгдийг захирч Ертөнцийн Эзэний зорилгод төгс үйлчилсээр байна.

Эцэст нь, Христ эргэн ирж Хаант улсаа бүрэн гүйцэд болгох үедээ энэ дэлхийд амьдарч байхдаа эхэлсэн зөв шударга байдлаа дуусгах болно. Тэрбээр Ертөнцийн Эзэний бүх дайсныг устгаж, Ер бусын эцгийнхээ яруу алдрын төлөө бүх зүйлийг шинэчилнэ. Тиймээс, бид Аврахаамын Ертөнцийн Эзэнд үнэнч байсан сэдвийг унших бүртээ Христэд итгэгч хүнийхээ хувьд энэ бүхнийг Аврахаамын үр удам болох Христтэй зөв холбосон үедээ л өнөөгийн дэлхий ертөнцөд үнэн зөвөөр хэрэгжүүлж чадна.

Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс

Гуравдугаарт, бид Ертөнцийн Эзэний хайр өршөөл болон хувь хүний үнэнч шударга байдлыг Христтэй нэгдсэн өнөөгийн амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг сонирхохоос гадна Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлс хэмээх удаах сэдвийг бас сайтар сонирхох хэрэгтэй. Израйль улс агуу үндэстэн болно гэж Ертөнцийн Эзэн Аврахаамд хэлсэн. Зөвхөн Ертөнцийн Эзэний амласан нутагт л ийм агуу үндэстэн болох бөгөөд Аврахаам, Израйль гэдэг нь бүх дэлхийд тархсан алдар суу нь түгсэн агуу нэрс болох ажээ.

Тийм учраас Христэд итгэгчийнхээ хувьд бид бодол санаагаа Аврахаамын үр удам болох Христэд Ертөнцийн Эзэний өгсөн сайн сайхан зүйлс рүү хандуулах хэрэгтэй. Христ энэ дэлхийд анх ирээд үхлээс дахин амилж, тэнгэр газрын бүх эрх мэдлийг хүлээн авсан юм. Тэгээд ч энэ дэлхийд Христийн нэрээс өөр агуу нэр байхгүй билээ. Христ Хаант улсаа үргэлжлүүлэн захирч байгаа одоо үед улам бүр нэмэгдсээр байгаа Ертөнцийн Эзэний ивээлийг эдэлсээр л байна. Тэрбээр энэ дэлхийг Ертөнцийн Эзэний хүслийн дагуу удирдаж байхдаа Өөрийгөө улам бүр алдаршуулсаар байна. Харин Христ яруу алдраа дуурьсган энэ дэлхийд дахин ирж Хаант улсаа бүрэн гүйцэд байгуулах үедээ Ертөнцийн Эзэний ивээлийг хэмжээлшгүй ихээр хүртэх болно. Тэрбээр бүхнээс өндөрт өргөмжлөгдөж,

Аврахаамын агуу хүү болох Түүний өмнө хүн бүр өвдөг сөгдөн хүндэтгэнэ. Тийм учраас Аврахаам Ертөнцийн Эзэнээс сайн сайхан зүйлсийг хүлээн авч байгаа тухай унших бүртээ бидний харц Аврахаамын амлалтыг өвлөн авч, Ертөнцийн Эзэний ивээл улам ихээр хүртэн буй Христ рүү чиглэх ёстой юм.

Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс

Эцэст нь, Аврахаамын амьдралаас урган гарах дөрөвдэхь гол сэдэв бол түүгээр дамжин хүмүүст ирэх сайн сайхан зүйлс юм. Аврахаамын анд нөхдийг ерөөж, өстөн дайсныг нь хараах үйл явцаар энэ дэлхийн бүх хүн түүгээр дамжин сайн сайхныг хүртэх болно гэж Ертөнцийн Эзэн хэлсэн. Энэ асар том амлалтанд Шинэ Гэрээ маш их анхаарал хандуулсан байдаг. Энэ амлалтын талаар Пууль Ромын 4-р бүлгийн 13-д юу гэж дурдсаныг сонсоцгооё. Тэрбээр,

Аврахаам болон түүний удам угсаанд хандан, 'Энэ дэлхий зөвхөн та нарынх болно' хэмээн Ертөнцийн Эзэн хэлжээ. Тэд өөрийнх нь хуулийг баг дагаж чадна гэж бодоод ингэж хэлээгүй юм. Харин өөрт нь итгэгч хэн боловч сайн үйлст гэмгүй хүн болж чадах байсан учраас үүнийг хэлжээ (Ром 4:13).

Аврахаам бүх үндэстнийг ивээнэ гэж Ертөнцийн Эзэн хэлэхдээ энэ бүхэн Аврахаам бүх үндэстнийг эзэмшилдээ авч, дэлхий даяар Ертөнцийн Эзэний хаант улсыг өргөжүүлэн тэлснээр биелэх боломжтой гэж амлаж байгааг анхаарах хэрэгтэй. Аврахаам болон түүний үр сад энэ дэлхийн өв залгамжлагчид болж бүх үндэстэн тэдний удирдлага дор орно. Ертөнцийн Эзэн эхлээд Адаам, Хаваах хоёрт энэ дэлхийг бүхэлд нь эрхшээлдээ оруул гэж хэлсэн. Харин Аврахаам болон түүний удам угсаанд үндэстэн бүрийн бүх гэр бүлд Өөрийнх нь ивээлээ тарааж, энэ дэлхийг бүхэлд нь өвлүүлэн өгөхөөр амласан юм.

Тэгэхлээр Христ нь Аврахаамын үр удам бөгөөд түүнд өгсөн амлалтын өв залгамжлагч учраас Аврахаамаар дамжин дэлхий даяар түгэх Ертөнцийн Эзэний ивээлийн тухай энэ сүүлчийн сэдэв Христэд ч бас хамаатай байв. Христ Хаант улсаа байгуулж эхлэхдээ Израйль үндэстэн дундаас зөв шударга хүмүүсийг дуудсан байдаг. Харин Тэрбээр үхлээс дахин амилж, бүх дэлхийн Хаан болон өргөмжлөгдөж, Ер бусын улсын хаан ширээнд залрахаар тэнгэрт одоходоо Өөрт нь үнэнч үлдсэн хүмүүст Израйльд оногдсон ивээлийг бүх үндэстэнд тараах тушаалыг өгсөн билээ. Христийн хаант улс цааш үргэлжлэн тогтнож байх үеэр Сайн мэдээгээр уламжлан Түүний хаанчлал бүх үндэстэнд хүрч байгаа нь Аврахаамаар дамжин улс үндэстэн бүрийг хамтрах Ертөнцийн Эзэний ивээлийн биелэл болж байна. Харин Христ эргэн ирж Хаант улсаа бүрэн байгуулж дуусах үед Тэрбээр Ертөнцийн Эзэний ивээлийг энэ дэлхийн бүх үндэстэнд хүргэх болно. Бид Үзэгдэл номын 22-р бүлгийн 1-ээс 2-т:

Тэгээд ер бусын элч хүн төрөлхтөнд ер бусын мөнхийн амьдрал өгөх

хүч чадлын бэлэг тэмдэг болох цэнгэг тунгалаг голыг надад үзүүлээ. Тэр гол уг хотод орших Ертөнцийн Эзэн, хурга Есүс Христ хоёрын ширээнээс гарч хотын гудамжны дундуур урсана. Бас тэр голын эргээр ер бусын мөнхийн амьдралын бэлэг тэмдэг болох жилд арван хоёр удаа жимслэдэг модод ургана. Тэрхүү моддын навчис нь хүн төрөлхтний эмгэг өвчин мэт гэмт муу чанарыг эдгээх хүч чадлын бэлэг тэмдэг ажээ (Үзэгдэл 22:1-2).

Аврахаам бүх үндэстэнд ивээл болно гэдэг амлалт нь эцсийн эцэст Христийн хаант улсын эхлэл, үргэлжлэл, төгсгөлөөр дамжин бүрэн биелэсэн юм.

Тэгэхлээр бид энэ бүхнийг ингэж хураангуйлж болно. Орчин үед Аврахаамын амьдралыг өнөөгийн дэлхий ертөнцөд үнэн зөв хэрэгжүүлэхийн тулд Христийн Аврахаамын үр удам гэсэн үүрэг ролийг далд ч болтугай хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ийнхүү Аврахаамын онцгой үр удам болсон Христ нь түүний амьдралаас бидний үзсэн дээрх 4 сэдвийг бүрэн илэрхийлж байна. Христийн амьдралд Ертөнцийн Эзэний өршөөл энэрэл харагддаг. Христ Ертөнцийн Эзэнд үнэн сэтгэлээсээ бүрэн төгс үнэнч байсан. Аврахаамд өгсөн бүх сайн сайхан зүйлийг Христ хүлээж авсан. Эцэст нь бид Аврахаамд өгсөн элбэг дэлбэг ивээлүүд нь Христээр дамжин энэ дэлхийн өнцөг булан бүрт тарж байгааг харлаа. Аврахаамын амьдралыг орчин үед хэрхэн хэрэгжүүлэх талаар олон зүйл хэлж болох ч бидний хувьд Аврахаам болох Христийн хоорондох эдгээр холбоог санаж байх нь туйлын чухал юм.

Аврахаам болон Есүсийн хоорондох харилцаа нь Аврахаамын түүхийг өнөөгийн бидний амьдралтай холбоход ямар чухал үүрэг гүйцэтгэж байгааг бид өмнөх хэсгээс харсан билээ. Одоо харин бүгдээрээ орчин үеийн хэрэгжүүлэлтийн хоёрдахь тал болох Израйль улс ба Христийн сүмийн хоорондох холбоог үзэцгээе.

ИЗРАЙЛЬЧУУД БА ХРИСТИЙН СҮМ

Аврахаамын амьдралын талаар Мөшэх бичиж байхдаа Израйлийн ард түмнийг Египет орныг ардаа орхиж Ертөнцийн Эзэний амласан нутгийг эзлэхээр нэвтрэн ороход нь зоригжуулах зорилготой байсан гэдгийг бид үргэлж санаж байх хэрэгтэй. Израйльчууд Аврахаамын амьдралаас Мөшэхийн энэ хэтийн зорилгын түүхэн нөхцөл байдлыг олж мэдсэн юм. Тэд Аврахаамын амьдралаас даган дуурайх эсвэл үгүйсгэн татгалзах үлгэр дууриалыг харж үүнийг биелүүлэх ёстой байв. Түүгээр ч барахгүй Аврахаамын амьдралд өөрсдийнх нь үзэж туулж буй бүхний урьдчилсан дохио болох зүйлс байгааг тэд ажигласан байна. Ийм учраас л бид Аврахаамын амьдралын түүхийг өнөөгийн дэлхий ертөнцөд хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгохын тулд Мөшэхийг дагаж явсан Израйль үндэстэн ба өнөөгийн Христийн сүмийн талаар Шинэ Гэрээ юу гэж зааж байгааг анхаарах хэрэгтэй.

Бид Израйльчууд ба Христийн сүмийн хоорондын харилцааг судлахын тулд өмнө үзсэн зүйлстэй зэрэгцэн орох 2 санааг авч үзэх болно. Эхлээд, бид Аврахаамын үр удам гэдэг санаа Израйль үндэстэн болон Христийн сүмд хэрхэн хэрэгжиж

байгааг улам лавшруулан судлана. Дараа нь, бид Аврахаамын үр удам гэдэг санааг түүний амьдралын түүхийг өгүүлэх нөгөө дөрвөн гол сэдэвт хэрхэн илэрхийлж байгааг үзнэ. За одоо Израйлчууд болон Христийн сүм нь Аврахаамын үр удам болох талаар үзэцгээе.

АВРАХААМЫН ҮР УДАМ

Ер нь бид Израильчууд ба Христийн сүмийн хоорондын холбоог Аврахаамын үр удамтай холбож ойлгохын тулд 4 асуудлыг товчхон хөндөх болно. Нэгдүгээрт, бид Аврахаамын үр удмын тооны хувьд хамрах хүрээг үзнэ. Хоёрдугаарт, бид түүний үр удмын угсаатны хувьд ялгарах шинжийг үзнэ. Гуравдугаарт, Аврахаамын үр удмын сүнсний мөн чанарт анхаарлаа хандуулна. Харин дөрөвдүгээрт нь, Аврахаамын үр удмын түүхэн нөхцөл байдлыг судлах болно. За эхлээд Аврахаамын үр удмын тооны хувьд хамрах хүрээг авч үзье.

тооны хувьд хамрах хүрээ

Бид дөнгөж сая Эхлэл номноос “Аврахаамын үр удам” гэдэг үг нь Яйцхаах хэмээх ганц онцгой бие хүнийг хэлсэн болохыг үзсэн. Харин үүнийг Шинэ Гэрээнд Аврахаам болон Христийн хооронд холбоо тогтоохын тулд гаргаж ирдэг. Харин одоо бид Аврахаамын үр удмын талаарх Библийн үзлийн өөр нэг талыг лавшруулан харах хэрэгтэй. Аврахаамын тухай түүхэнд ганцхан Яйцхаахыг л түүний үр удам буюу удам угсаа гэж хэлээгүй. Яйцхаах зөвхөн ганцаараа л Аврахаамын өвийг хүлээн аваагүй билээ. Тэрбээр мөн олон хүнийг Аврахаамын удам угсаа гэдэг статустай болж баярлан бахдах суваг нь болсон юм. Ийм л шалтгааны улмаас Израиль үндэстнийг Мөшэх дахин дахин Аврахаамын үр удам гэж хэлж байсан ажээ. Яг үүнтэй адил бид Аврахаамын түүхийг орчин үеийн дэлхий ертөнцөд хэрэгжүүлэхдээ Христ бол Шинэ Гэрээнд дурдсан Аврахаамын агуу үр удам гэдгийг санаж байх хэрэгтэй. Бид бас Христийн сүм бол Аврахаамын үр удам гэдгийг ч мартаж болохгүй. Пууль Галатын 3-ийн 29-д:

Та нар . . . Аврахаамын удам болсон. Мөн түүнд Ертөнцийн Эзэний амласан зүйлийг хүлээн авах өв залгамжлагчид болсон юм (Галат 3:29).

Энэ ишлэлд Пууль тодорхой хэлсэн шиг бид Христтэй нэгдсэн учраас л Аврахаамтай холбоотой болсон юм. Бид Хуучин Гэрээний үеийн Израиль үндэстэн шиг Аврахаамын үр удам болсон билээ. Тийм учраас Аврахаамын түүх нь зөвхөн Христэд хамаатай бус, Түүний сүмд Түүнтэй нэгдмэл болсон Аврахаамын үй олон хүүхдийг бас хамардаг юм.

угсаатны хувьд ялгарах шинж

Тэгэхлээр Аврахаамын үр удам нь Хуучин Гэрээний үеийн Израйльчууд болон өнөө үеийн Христийн сүм гэдэг баримтаас гадна бид Хуучин ба Шинэ Гэрээний үеийн Аврахаамын үр удмын угсаатны хувьд ялгарах шинжийг дурдах хэрэгтэй болов уу. Анх Аврахаамын түүхийг Мөшэхийг дагаж байсан Израйль үндэстэнд зориулан бичсэн гэдгийг бид үзсэн. Энэ түүхийн анхны уншигчдийн ихэнх нь угсаатны хувьд Аврахаамын цусан төрлийн Еврейчүүд байсан гэдэг нь үнэн боловч тэд бүгд цэвэр Еврейчүүд байсан гэж бодох нь эндүү ташаа ойлголт юм шүү. Мөшэхийг дагаж байсан хүмүүсийн дотор нэлээд олон хүн Израйльд үрчлэгдсэн Еврей бус хүмүүс буюу тэдний үр хүүхдүүд байжээ. Тэгээд ч Ертөнцийн Эзэний сургаалийн нэлээд хэдэн хэсгээс Эхлэл номын анхны уншигчид нь зөвхөн Еврейчүүд байгаагүй гэдэг нь тодорхой харагддаг.

Жишээлбэл, Мөшэхийг дагаж явсан хүмүүсийн тухай “Египетээс гарсан нь” номын 12-ийн 38-д:

Тэдэнтэй хамт өөр олон хүн, мөн хонь, үхэр гээд олон тооны мал сүрэг хамт гарав (Египетээс гарсан нь 12:38).

Энд Израйльчуудаас гадна өөр олон хүн гарсан тухай өгүүлж байгааг анзаарах хэрэгтэй. Эд нар бол Израйльчуудтай нэгдээд тэдэнтэй хамт Египетийг орхин гарсан Еврей бус хүмүүс юм. Ийм бүлэг хүмүүсийн тухай Библид нэлээд олон газар дурддаг. Хуучин Гэрээний сүүлчийн хэсгүүдэд Израйльчуудын хожмын үеийнхэнтэй холбоотой болсон Рахааб, Руут зэрэг нэрд гарсан Еврей бус хүмүүсийн тухай ил тод бичсэн байдаг билээ. Мөн “Шастирын дээд” номын 1-ээс 9-р бүлэгт Ертөнцийн Эзэний хүмүүсийн дунд Еврей бус хүмүүсийн нэрс байдаг.

Тэгэхлээр Аврахаамын түүхийн талаар Мөшэхийн анх хандаж бичсэн Аврахаамын үр удам гэгдэх хүмүүс нь угсаатны хувьд холимог байсныг бид үзлээ. Тэдний тоонд Аврахаамын цусан төрлийн удам болон Израйльчуудын гэр бүлд үрчлэгдэн орсон Еврей бус хүмүүс багтаж байна. Энэ хоёр бүлгийн хүмүүс бүгд Аврахаамын түүхээс Амласан нутаг дахь ирээдүйнхээ тухай мэдэж авсан юм.

Яг үүнтэй адил өнөөгийн Христийн сүмд угсаатаны хувьд олон янзын хүн байдаг. Үүнд Христийг өөрсдийн Их Эзэнээ гэж хүлээн зөвшөөрсөн Еврейчүүд болон Аврахаамын гэр бүлд үрчлэгдсэн Еврей бус хүмүүс багтаж байлаа. Тэд ч бас Христийг Их Эзэнээ гэж хүлээн зөвшөөрсөн ажээ. Гэхдээ түүх бидэнд Шинэ Гэрээний Сүм нь Христийг хүлээн авсан Еврейчүүдээс илүү Аврахаамын гэр бүлд үрчлэгдэн орсон Еврей бус хүмүүсээр улам бүр өргөжиж байгааг харуулдаг. Аврахаамын үр удам нь Хуучин Гэрээний үе шигээ угсаатаны хувьд олон янзын хүмүүсээс бүрдэж байгаа нь өнөөгийн бодит байдал болжээ. Тиймээс анх Аврахаамын түүхийг түүний үр удам гэж тооцогдож байсан Еврей болон Еврей бус хүмүүст хандан бичсэн шиг, өнөө үед үүнийг Еврей болон Еврей бус хүмүүст хамааруулан хэрэгжүүлэхэд бэлэн байх хэрэгтэй. Учир нь бид дэлхий даяар тархсан Христийн сүмд харъяалагддаг учраас Аврахаамын үр удам гэж тооцогдох болсон

билээ.

Энэ нь орчин үед Аврахаамын түүхийг амьдралд хэрэгжүүлэхэд хэрэгтэй маш чухал ойлголт юм шүү. Учир нь Христэд итгэгч олон хүн Аврахаамд өгсөн амлалт нь зөвхөн Еврей угсааны хүмүүст л хамаатай гэдэг худал сургаалыг сурталчилж байна. Тэдний үзлээр бол Ертөнцийн Эзэн Еврей бус итгэгчдэд зориулсан өөр хөтөлбөртэй ажээ. Зарим нэг нийтлэг зарчмыг үл тооцвол, Еврей бус итгэгчид нь Аврахаамд өгсөн амлалтыг өвлөн авах хүмүүс биш гэж тэд үздэг. Харин бид ийм үзэл бодол хир их түгсэнийг үл харгалзан, Мөшэхийн үед Аврахаамын үр удамд угсаатаны хувьд олон янзын хүмүүс багтаж байсан шиг, өнөө үед ч гэсэн Аврахаамын үр удмын тоонд олон янзын угсаатан багтдаг гэдгийг санаж байх хэрэгтэй. Өөрийг нь дагаж байсан үндэстэнд Мөшэхийн зааж байсан зүйлс нь тэр үндэстний үргэлжлэл болсон Есүс Христийн сүмд ч бас хамаатай.

сүнсний мөн чанар

Гуравдугаарт, Аврахаамын амьдралыг орчин үед хэрэгжүүлэхийн тулд түүний үр удам болох Израйльчууд болон өнөөгийн Христийн сүмийн сүнсний мөн чанарыг анхааралдаа авах хэрэгтэй. Нүдэнд үзэгдэх Израйль үндэстэнг Аврахаамд хамаатай үр удам нь болох талаар Хуучин Гэрээнд тодорхойлж байгааг бид харсан. Гэхдээ энэ нүдэнд үзэгдэх Израйль үндэстэн нь сүнслэг байдлын хувьд олон янз байсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэдний дунд үл итгэгчид ч, жинхэнэ итгэгчид ч байсан. Хуучин Гэрээний мэдээ баримтаас харахад Израйль үндэстний дунд Ертөнцийн Эзэнд үнэн сэтгэлээсээ итгээгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүд байсан нь тодорхой байдаг. Мөн Ертөнцийн Эзэний амлалтанд бүрэн итгэдэг жинхэнэ итгэгчид бас байсан. Гэхдээ итгэгчид, үл итгэгчид гээд Израйлийн хүн бүр Ертөнцийн Эзэний түр зуурын тусгай ивээлийг хүртэж байв. Тэд бүгд Египетийн боолчлолоос чөлөөлөгдсөн. Бас бүгдээрээ Синай уулан дээр Ертөнцийн Эзэнтэй гэрээний харилцаанд орсон. Тэдэнд бүгдэд нь Ертөнцийн Эзэнд итгэх маш олон боломж байсан бөгөөд бүгдэд нь Амласан нутагт орох урилга өгсөн юм. Гэхдээ тэдний хооронд маш чухал ялгаа байсан. Нэг талаар Израйльчуудын дунд буй үл итгэгчид нь Ертөнцийн Эзэнд үнэнч бус байж зүрх сэтгэлийнхээ жинхэнэ мөн чанарыг харуулдаг билээ. Тэднийг гэмт байдлаа орхиж, авралд хүргэх итгэлтэй болох тухай Аврахаамын түүхэнд олонтоо дурддаг.

Нөгөө талаар Израйльчуудын дунд буй жинхэнэ итгэгчид нь Ертөнцийн Эзэний амлалтанд итгэж, Түүнд үнэнч байснаараа зүрх сэтгэлийнхээ жинхэнэ мөн чанарыг харуулдаг. Ийм жинхэнэ итгэгчдийг итгэлээрээ өсөхөд нь урамшуулах зорилготой хэсэг Аврахаамын түүхэнд бас олон байдаг. Тэгэхлээр Израйльчуудын дунд буй үл итгэгчид нь зөвхөн түр зуурын ивээлийг хүлээн авах бөгөөд үнэнч бус байдлаасаа болоод алс хэтдээ Ертөнцийн Эзэний мөнхийн шийтгэлийг авах юм. Харин жинхэнэ итгэгчид бол Аврахаамын жинхэнэ үр удам, түүний сүнслэг удам угсаа үр хүүхдүүд нь юм. Тэд зөвхөн түр зуурын ивээлд сэтгэл ханадаггүй бөгөөд хожим нэгэн өдөр шинэ тэнгэр шинэ дэлхий бүхий мөнхийн улсад Аврахаамын өвийг мөнхөд хүлээн авах болно. Пууль ийм үзэл бодлыг Ромын 9-р бүлгийн 6-аас

8-д нэлээд хүчтэй гаргаж ирсэн байдаг. Тэнд тэрбээр.

Олонхи Израйль хүн Ертөнцийн Эзэний үгийг дагаагүй учраас түүнийх болж чадсангүй. Израйльчууд үнэндээ бүгд Аврахаамын удам боловч бүгд Ертөнцийн Эзэнийх болж чадсангүй. Тэгээд ч Аврахаамд, 'Хүү Яйцхаахын чинь удам угсаа чиний жинхэнэ удам болно' гэж хэлсэн билээ. Өөрөөр хэлбэл Аврахаамаас жирийн байдлаар үүссэн хүүхдүүд түүний удам болоогүйгээр барахгүй Ертөнцийн Эзэнийх ч болсонгүй (Ром 9:6-8).

Христийн сүмд ч гэсэн сүнсний хувьд иймэрхүү олон янз байдгийг олж харахад тийм ч хэцүү бишээ. Усан баталгаа хийлгэж, нүдэнд үзэгдэх Шинэ Гэрээний сүмтэй холбоотой болсон хүмүүс ч гэсэн үл итгэгчид ба итгэгчид гэсэн хоёр бүлгээс бүрддэг. Мэдээж Ертөнцийн Эзэн болон Түүний ард түмэнтэй холбоотой байсан учраас Хуучин Гэрээний үеийн Израйль оронд амьдарч байсан бүх хүн маш олон түр зуурын ивээл хайрыг хүртэж байсан шиг өнөөгийн Христийн сүмд явж буй бүх хүн маш олон түр зуурын ивээлийг хүртэж байна. Тэд өөрсдийг нь хайрладаг хамт олонтой. Тэдэнд Ертөнцийн Эзэний Үг, даган биелүүлэх ёслол байна. Санал болгож тайлбарлаж өгсөн Сайн мэдээ ч байна. Гэвч нүдэнд үзэгдэх Христийн сүмийн олон хүн үнэнч бус байдлаараа зүрх сэтгэлийнхээ жинхэнэ мөн чанарыг харуулдаг. Тиймээс Аврахаамын түүх нь Христийн сүмд буй иймэрхүү итгэгчдийг гэмт амьдралаа орхиж, авралын итгэлийг хүлээж авахад тусалдаг юм.

Нүдэнд үзэгдэх Христийн сүмд Ертөнцийн Эзэний амлалтанд итгэж, Түүнд үнэнч байгаагаа зүрх сэтгэлээсээ харуулдаг жинхэнэ итгэгчид бас байдаг. Аврахаамын түүх нь иймэрхүү жинхэнэ итгэгчдэд амьдралынхаа турш итгэлээрээ өсөхөд нь урамшуулан зоригжуулдаг юм. Тэгэхлээр Ертөнцийн Эзэнд үнэнч бус байснаараа Христийн сүмд буй үл итгэгчид нь түр зуурын ивээлийг хүртдэг. Харин тэд мөнхийн амьдралдаа Ертөнцийн Эзэний мөнхийн шийтгэлийг хүртэх болно. Харин Аврахаамын жинхэнэ үр удам, жинхэнэ хүүхдүүд нь түр зуурын олон ивээлийг хүртэхээс гадна ирээдүйд нэгэн өдөр шинэ тэнгэр шинэ дэлхий бүхий мөнхийн улсад ороод Аврахаамын өвийг мөнхөд хүртэх эрхээр шагнуулах юм.

Тийм учраас Яахооб Аврахаамын тухай өөрийн захидлын 2-р бүлгийн 22-23-д бичсэн байдаг. Тэрбээр үл итгэгчид болон жинхэнэ итгэгчдээс бүрдсэн нүдэнд үзэгдэх Христийн сүмд хандан ингэж бичсэн байна:

Бидний өвөг Аврахаам хүү Яйцхаахаа өргөл болгон өргөхөөс буцахгүй байсан учраас Ертөнцийн Эзэн түүний гэмийг цагаатгасан биз дээ? Аврахаам Ертөнцийн Эзэнд итгэж байсан учраас үгийг нь дагаж тэр итгэл нь хир зэрэг бодитой болохоо харуулсан юм (Яахооб 2:21-22).

Яахооб энд Аврахаамын түүх нь Христийн сүмд буй үл итгэгчдийг хоёр нүүр гаргах хуурамч байдлаасаа салахыг уриалсан бол жинхэнэ итгэгчдийг гэм буруугүй зөв амьдралаараа итгэлээ үргэлжлүүлэхийг урамшуулан дэмжсэн гэдгийг гол нь хэлэх гэж хичээсэн байна. Тийм учраас бид Аврахаамын түүхийг орчин үед

хэрэгжүүлэхдээ өнөөгийн Христийн сүмд буй сүнсний олон янз байдлыг ухааран ойлгож Яахообын үлгэр жишээг дагах ёстой юм.

Түүхэн нөхцөл байдал

Дөрөвдүгээрт, Аврахаамын амьдралын түүхийг орчин үеийн ертөнцөд хэрэгжүүлэхдээ Мөшэхийг дагаж байсан Израйльчууд ба өнөөгийн Христийн сүмийн түүхэн нөхцөлийн хооронд нэлээд утга учиртай ижил төстэй байдал байгааг бас санах хэрэгтэй. Мөшэх аян замд нүүдэллэн яваа Израйльчуудад зориулж Аврахаамын амьдралын тухай бичсэн гэдгийг та нар санаж байгаа байх. Тэрбээр Египетээс гарсан хүмүүст эсвэл тэдний дараагийн үед хандсан бичсэн ч гэсэн түүний анхны уншигчид хоёр ертөнцийн хооронд нүүдэллэж байсан юм. Нэг талаар тэд Египетийн боолчлолоос салаад удаагүй байв. Нөгөө талаар тэд Ертөнцийн Эзэний амласан Хинаан нутагт хараахан ороогүй байв. Өөрөөр хэлбэл Израйль үндэстэн нь хуучин ертөнцөөс эхлээд чөлөөлөгдсөн боловч шинэ ертөнцдөө хараахан ороогүй байлаа. Энэ байдлаас болоод Мөшэх Израйльчуудыг Египеттэй холбоотой бүх зүйлээс салж, зорьсон нутагтаа ялалт байгуулах замаар урагшлахыг урамшуулан дэмжиж бичсэн байна.

Анхны уншигчдад тохиолдсон түүхэн нөхцөл байдал нь орчин үеийн хэрэгжүүлэлтэнд маш чухал байдаг. Учир нь өнөөгийн Христийн сүм нь түүхэн нөхцөлийн хувьд ижил байдалд байна. Израйльчууд Египетийн дарлалаас чөлөөлөгдөөд Ертөнцийн Эзэний амласан нутагт буй яруу алдарт амьдрал руу зүглэсэн шиг, Христэд итгэгчид нь энэ дэлхийд ирээд хийсэн Есүсийн ажлаас болж гэмийн ноёрхолоос чөлөөлөгдсөн ч, Түүнийг дахин эргэж ирэхэд боломжтой болох яруу алдарт шинэ бүтээл болохоор зүтгэж байна. Ийм зэрэгцээ нөхцөл байдал нь өнөөгийн Христийн сүмд Аврахаамын амьдралыг хэрхэн хэрэгжүүлэх санааг бидэнд өгдөг юм. Холын аянд яваа Израйльчуудыг нэг нутгаас нөгөө нутаг руу нүүдэллэх үед нь газарчилж, тэдэнд урам зориг өгөхийн тулд Аврахаамын тухай Мөшэх бичсэн шиг, энэ түүх нь үхлийн ертөнцөөс ангижирч мөнхийн амьдрал өгөх шинэ ертөнц рүү аялан буй биднийг удирдаж, урамшуулан зоригжуулдаг билээ.

Иймэрхүү түүхэн зэрэгцээ байдал нь бидэнд энэ бүхнийг хэрхэн хэрэгжүүлэх чиг хандлага болдог юм. Учир нь Есүсийн төлөөлөгч Пууль Хуучин Гэрээний ийм түүхийг Коринф хотын итгэгчдэд хэрэглэсэн байдаг. Тэрбээр Мөшэхийн уншигчид болон Христэд итгэгчдийн хоорондын түүхэн зэрэгцээ байдлыг юу гэж бичсэнийг бүгдээрээ 1 Коринфийн 10-р бүлгийн 1-ээс 6-аас үзэцгээе. Тэнд:

Ертөнцийн Эзэн өвөг дээдэстэй маань хамт байгаагаа харуулж дэргэд нь өтгөн үүл манан байлгаж, Улаан тэнгисийг гатлахад хуурай газар гаргаж өгсөн баримтыг та нар битгий мартаасай гэж би хүсэж байна. Үүгээрээ Израйльчууд Мөшэхээр усан баталгаа хийлгэсэнтэй адил юм. Бүх Израйль хүн Ертөнцийн Эзэний өгсөн хоолыг идэж, Түүний өгсөн усыг хаднаас ууж байв. Тэр хад бол Израйльчуудын хамт одоо үргэлж хамт байгаа Христийн бэлэг тэмдэг юм. Гэвч тэд Ертөнцийн

Эзэний хүмүүс болохоо мэдсэн хирнээ элдвийн муу юм хийсээр түүнээсээ шийтгэл авч, ихэнх нь цөлд байхдаа үхжээ. Тэгэхлээр тэдгээр Израйльчууд шиг гэм хийж болохгүй гэдгийг бидэнд ойлгуулахын тулд энэ бүхнийг жишээ болгосон байна (1 Коринф 10:1-6).

Товчхон хэлэхэд, Мөшэхийг дагаж цөлд явж байсан Израйльчуудын үзэж мэдэрсэн бүхэн Христэд итгэгчидтэй тохиолдож буй бүхэнтэй зэрэгцэн оршиж байгаа мэт байдаг. Тэднийг Мөшэх чөлөөлсөн бол биднийг Христ чөлөөлсөн юм. Христэд итгэгчид усан баталгаа хийлгэж Христтэй нэгдсэн шиг тэд Мөшэхтэй хамт Улаан тэнгэсийг гаталсан нь усан баталгаа хийлгэсэнтэй адил юм. Тэд манна идэж, Ертөнцийн Эзэний өгсөн хаднаас ундаалж байсан бол Христ итгэгчид Хайрын зоог барьдаг билээ. Израйльчуудад үзүүлсэн Ертөнцийн Эзэний энэ эхний хайр өршөөл бол тэднийг Амласан нутаг руу явж байхад нь туршиж шалгасан үе байсан юм. Харамсалтай нь Мөшэхийн үе маш олон Израйль хүн гэм хийж Ертөнцийн Эзэнд таалагдаагүй учраас цөлд байхдаа үхэцгээсэн байна. Тиймээс Пууль Христэд итгэгчид бол Христийн сүмийнхээ хувьд хийж буй аялалынх нь мөн чанар болох Израйльчуудын туршлагаас суралцах ёстой гэсэн дүгнэлт хийв.

Пуулийн хэрэглэсэн жишээнээс бид Аврахаамын амьдралыг өнөөгийн Христийн сүмд хэрхэн хэрэгжүүлэх талаар ихийг сурч чадна. Аврахаамын амьдалын тухай бичсэн Мөшэхийн түүх нь Израйльчуудыг Египетийн дарлалаас чөлөөлөхийн тулд Ертөнцийн Эзэн юу хийснийг эргэж дурсаж, Түүний амласан нутгийн зүг урагшлахад нь урам зориг өгч байлаа. Яг л үүн шиг бид мөнхийн амьдрал хүрэх аянд явж байхад маань өнөөгийн Христийн сүмийг урамшуулах зорилгоор Аврахаамын түүхийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Христ хаант улс анх байгуулахдаа бидний төлөө хийсэн бүгдээс болж бид Түүнд үнэнч байх ёстой юм. Өнөө үед Христийн хаант улс өргөжин тэлж байхад ч гэсэн бид Түүнд үнэнч байх хэрэгтэй. Мөн бид сүнслэг аялалаа дуусгаж шинэ тэнгэр, шинэ дэлхий бүхий мөнхийн амьдралд орох өдрөө хүсэмжлэн хүлээдэг билээ.

Тэгэхлээр бид Аврахаамын амьдралыг орчин үед хэрэгжүүлэхдээ зөвхөн Аврахаам болон Есүсийн хоорондын холбоонд өөрсдийн эзлэх байр суурийн талаар санаа тавих хэрэггүй. Бид Аврахаамын түүхийг анх хүлээн авсан Израйль үндэстэн ба Христийн сүмийн хоорондын холбоонд бас анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хуучин Гэрээний Израйльчууд ба Шинэ Гэрээний Христийн сүм нь Аврахаамын үр удам мөн. Бид хоёулаа угсаатаны хувьд холилдсон хүмүүсээс бүрддэг. Бид итгэлийн хувьд янз бүрийн байдалтай байдаг. Бид бас Ертөнцийн Эзэний яруу алдарт хаант улсад очих аян замдаа явж байгаа хүмүүс билээ.

ГОЛ СЭДВҮҮД

Бид Аврахаамын амьдралын түүх нь өнөөгийн дэлхий ертөнцөд буй Аврахаамын үр удмын үргэлжлэл болсон Христийн сүмд хэрхэн хэрэгжиж байгааг үзлээ. Үүнийг үзэж байхдаа бид энэ хэрэгжих үйл явц нь Аврахаамын амьдралын

тухай өгүүлсэн бүлгүүдэд гардаг нөгөө 4 гол сэдвийг хэрхэн хөндөж байгааг бас харах хэрэгтэй. За тэгвэл эдгээр сэдэв нь Христтэй нэгдмэл бидний өдөр тутмын амьдралын талаар юу гэж хэлсэн байдаг вэ?

Аврахаамын түүх нь дараах 4 сэдвийг хөнддөгийг та нар санаж байгаа байх. Эдгээр нь Ертөнцийн Эзэний хайр өршөөл, Аврахаамын үнэнч байдал, Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс болон Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс юм. Аврахаамын үр удам болох бидний амьдралын талаар эдгээр сэдэв юу гэж өгүүлж байгааг үзэцгээе. Гэхдээ би одоо энэ тухай үзэхдээ бидний даган баримтлах зүйлийн талаар товч өгүүлэх болно. Эхлээд Ертөнцийн Эзэний хайр өршөөл гэдэг сэдвийг авч үзье.

Ертөнцийн Эзэний хайр өршөөл

Ертөнцийн Эзэн Аврахаамын амьдралын эхэн үед бус, энэ дэлхий дээр амьдарч байсан өдөр бүр түүнд өршөөл энэрлээ харамгүй үзүүлж байв. Ертөнцийн Эзэн Аврахаамд өршөөл энэрлээ үзүүлж байсан шиг, итгэгч биднийг өнөөдөр ч гэсэн Христтэй хамт байлгаж өршөөл энэрлээ үзүүлсээр байдаг хэмээн Библи маш тодорхой заадаг билээ. Энэ тухай Пууль Эфэсийн 2-р бүлгийн 8-аас 9-д:

Тэгэхлээр та нар Ертөнцийн Эзэний хайр өршөөлөөр аврагдсан юм. Аврал бол та нарын хүчин чармайлтын үр дүн бус, Ертөнцийн Эзэний өгсөн бэлэг юм. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхаж чадахгүй (Эфэс 2:8-9).

Христэд буй аврал нь Ертөнцийн Эзэний өгсөн өгөөмөр бэлэг юм. Түүгээр ч барахгүй бидний итгэл Түүнээс ирдэг. Бид Ертөнцийн Эзэний өршөөл энэрлээс үлэмж хамааралтай аж төрдөг юм. Өдөр бүр бид энэ хайр өршөөлөөр дамжуулан Христэд итгэгч хүний амьдралаар үргэлжлүүлэн амьдарч байдаг. Ертөнцийн Эзэний үргэлжийн хайр өршөөл байхгүй бол гэм буруугүй амьдрах гэсэн бидний бүх хүчин чарайлт огт хэрэггүй болдог.

Ийм л шалтгааны улмаас Мөшэхийг дагаж буй Израйльчууд Аврахаамын түүхийг сонсоод өөрсдийнх нь амьдралд хийсэн Ертөнцийн Эзэний гайхамшгийг олж мэдсэн шиг бид Христийн дагалдагч хувь хүнийхээ ч, сүм цуглааныхаа хүрээнд ч гэсэн Аврахаамын түүхийг унших бүртээ бидний төлөө Ертөнцийн Эзэний хийсэн бүхэнд хэрхэн талархахыг сурах боломжтой байдаг юм. Ертөнцийн Эзэн бидэнд маш их хайр өршөөлөө харуулсан билээ. Бид Түүний хайр өршөөлийг хүсэмжлэн тэмүүлж, түүнээс нь хамааралтай байж сурах хэрэгтэй.

Аврахаамын үнэнч байдал

Яг дээрхтэй адил Аврахаамын үнэнч байдал гэдэг сэдэв нь Христийн дагалдагчдад маш олон янзын түвшинд хамаатай байдаг. Бид Аврахаамын

амьдралын тухай уншиж байхдаа түүний амьдралын олон тохиолдолд өөрт нь дуулгавартай байхыг Ертөнцийн Эзэн тушааж байгааг хардаг. Мэдээж Аврахаам энэ амьдралдаа төгс төгөлдөрийн дээдэд хүрээгүй ч, жинхэнэ итгэлийнхээ үр жимсийг харуулж байсан. Тиймээс Хуучин Гэрээний үед ч гэсэн үнэнч дуулгавартай байна гэдэг нь Ертөнцийн Эзэний хайр ивээл, өршөөл энэрэл дээр үндэслэж байсан гэдгийг санах хэрэгтэй. Харин үүнийг бид аливаа хууль дүрмийг сохроор дагах үйлдэлтэй холбон ойлгож алдаа гаргаж болохгүй. Өнөөгийн жинхэнэ итгэгчид нь Хуучин Гэрээний итгэгчид шиг Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг Түүнд үнэнчээр үйлчилж хариулдаг юм.

Христийн дагалдагчдын үнэнч байдлын талаар Шинэ Гэрээ байнга онцолж бичсэн байдаг нь ийм учиртай юм. Пууль хайр өршөөл ба үнэнч байдлыг хооронд нь хэрхэн холбож байгааг Эфэсийн 2-р бүлгийн 8-аас 10-т үзэцгээе. Тэнд:

Тэгэхлээр та нар Ертөнцийн Эзэний хайр өршөөлөөр аврагдсан юм. Аврал бол та нарын хүчин чармайлтын үр дүн бус, Ертөнцийн Эзэний өгсөн бэлэг юм. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхаж чадахгүй. Биднийг Есүс Христтэй нэгдэж сайн үйлс бүтээлгэхийн тулд Ертөнцийн Эзэн бүтээсэн юм. Тэрбээр үүнийг өнө эртнээс шийдсэн ажээ (Эфэс 2:8-10).

Өнөө үед Христэд итгэгчид нь сайн үйлс бүтээх үүрэгтэй гэдгийг 10-р ишлэл тодорхой харуулж байна. Ертөнцийн Эзэн бидэнд авралын итгэлийг өгсөн учраас бид Түүнд үнэнч байдаг. Тэгэхлээр Аврахаамын амьдрал нь хүний үнэнч байдалтай холбогдож байгааг харах бүртгээ бид амьдралдаа иймэрхүү ёс суртахууны хариуцлага хүлээх ёстой гэдгээ ойлгодог юм.

Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс

Гуравдугаарт, бид Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлсийг Христэд итгэгч хүний амьдралдаа хэхэн хэрэгжүүлэх талаар тунгаан бодох хэрэгтэй. Аврахаам болон түүний үр удмыг Ертөнцийн Эзэн маш их ивээхээ амласан гэдгийг та нар санаж байгаа байх. Угтаа бол тэд асар их нэр хүндтэй, хөгжин дэвшсэн агуу үндэстэн болох байлаа. Бид Аврахаамын амьдралын түүхээс Ертөнцийн Эзэнд түүнд энэ бүх сайн сайхан зүйлийг урьдчилан бага зэрэг өгч байгааг хардаг.

Мөшэхийн анхны уншигчид болох Израйльчууд нь Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний амлалт өөрсдийнх нь амьдралд бүрэн биелэхийг хүлээж байлаа. Үүнтэй адил Христэд итгэгчид бид ч гэсэн иймэрхүү сайн сайхан зүйлийг авч байгаа ч хожим нэг өдөр эдгээрийг бүрмөсөн хүртэнэ хэмээн найдан хүлээж байгаа билээ. Энэ бүх сайн сайхан зүйлс Христийг эргэж ирэхэд хамгийн агуу ивээлийг хүртэнэ гэсэн найдлага тээн өдөр бүр амьдарч байхад маань асар их урам зориг өгдөг юм.

Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс

Эцэст нь, Аврахаамын түүх түүгээр дамжин хүн төрөлхтөнд ирсэн Ертөнцийн Эзэний ивээлд анхаарлаа хандуулсан байдаг. Христэд итгэгчид ч гэсэн өөрсдөөр нь дамжин хүн төрөлхтөнд ирсэн ивээлийг харуулах боломжтой байдаг юм. Ертөнцийн Эзэн Аврахаамыг өстөн дайснуудаас нь хамгаалж, анд нөхдөд нь ивээл болгоно гэж амласныг та нар санаж байгаа байх. Тэрбээр нэгэн цагт Ертөнцийн Эзэний ивээлийг дэлхийн бүх үндэстэнд тараах ёстой байлаа. Үүнээс гадна Ертөнцийн Эзэн Аврахаамыг олон янзын хүмүүст Өөрийнхөө ивээлийг дамжуулах хэрэгслэл болгож ашиглаж байсныг бид үзсэн.

Эхлэл номын анхны уншигчид энэ бүх үйл явдлын талаар олж мэдээд тухайн үед болж байсан зүйлийг ухаарсан байдаг. Тэд янз бүрийн бүлгийн хүмүүстэй уулзаж учраад тэдэнд хэрхэн Ертөнцийн Эзэний ивээлийг дамжуулах хэрэгслэл болох зааврыг олж мэдсэн юм. Тэд Ертөнцийн Эзэн дайснуудаас нь хамгаалж байгааг баттай мэдэж байсан тул хөрш улс орондоо Түүний хаант улсын ивээлийг тараах хүчин чармайлт гаргах ёстой байлаа.

Яг үүнтэй адил өнөө үед Христэд итгэгч бид энэ санааг амьдралдаа ажил хэрэг болгох хэрэгтэй. Бид Ертөнцийн Эзэний хамгаалалтанд бүрэн найдаж, Түүний хаант улсыг энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэж, бүх улс үндэстэнд ивээл болох урам зоригийг ч авдаг билээ.

ДҮГНЭЛТ

Бид Аврахаамын амьдралыг орчин үед хэрэгжүүлэх тухай энэ хичээлээр үзэхдээ Эхлэл номонд гарч буй Израйлийн энэ алдарт өвгийн амьдрал өнөөгийн бидний дэлхий ертөнцтэй хэрхэн холбогдож байгааг судаллаа. Есүст итгэгчид Библийн энэ хэсгийг судлахдаа Христийг Аврахаамын агуу үр удам болох тал дээр гол анхаарлаа хандуулдаг болохыг бид эхлээд үзсэн. Аврахаамын амьдралыг судлахдаа бидний олж мэдсэн дээрх сэдвүүд нь Христийн амьдралыг бүрэн хамарсан болохыг ч харсан. Үүнээс гадна Аврахаамын үр удмуудын нэгдэл болсон Христийн сүмд ч гэсэн Аврахаамын амьдрал хэрхэн хэрэгжиж байгааг бид бас үзсэн. Христтэй нэгдмэл болсон эрэгтэй эмэгтэй хүмүүс, хүүхдүүд гээд хэн болов ч Библийн энэ хэсэгт буй сургаалийн дагуу хэрхэн амьдрах ёстойг ч үзлээ.

Бид Эхлэл номонд өгүүлсэн Аврахаамын амьдралыг нарийвчлан судлах тусмаа тэр бүхнийг өөрсдийнхөө өнөөгийн амьдралд хэрэгжүүлэх маш олон боломжийг олж хардаг юм. Ийнхүү бид Аврахаам эцгийн тухай бичсэн Мөшэхийн үгийг уншаад түүнтэй зүрх сэтгэлээсээ ойр болохоос гадна түүний үр удам болох Христтэй ойр болдог. Улмаар Христтэй нэгдмэл болсон бид ч гэсэн Аврахаамын хүүхдүүд болж, түүнд амласан Ертөнцийн Эзэний амлалтын өв залгамжлагчид мөн гэдгээ мэдэх гайхамшигт мөчтэй учирдаг билээ.

Др.Ричард Л. Прагг. (Host) is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open*, *Every Thought Captive*, *Designed for Dignity*, *He Gave Us Stories*, *Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.

ҮГСИЙН ТАЙЛБАР

гэрээ (covenant) – Хоёр хүн эсвэл бүлэг хүмүүсийн хооронд, мөн Бурхан аливаа хүн ба бүлэг хүмүүстэй байгуулсан заавал биелүүлэх үүрэг бүхий хууль ёсны хэлцэл

Гэтлэл (exodus) – Израил ард түмэн Египетийн боолчлолоос чөлөөлөгдсөн үйл явдал.

Рахааб (Rahab) – Израил туршуулуудыг Амлагдсан нутагт ороход тус болсон Еврей бус эмэгтэй. Тэрээр Эрийхүү хотыг эзлэгдсэний дараа Израилчуудтай нэгдсэн

Руут (Ruth) – Наоми гэдэг эмэгтэйн Муаб үндэстэн бэр. Тэрээр хожим Богзтай гэрлэж Израил үндэстэнд нэгдсэн. Түүний удмаас Давид хаан болон Есүс төрсөн.

Синай (Sinai) – Мөшэхийн үед Ертөнцийн Эзэний Израилтай гэрээгээ байгуулж арван хуулиа өгсөн уулын нэр.

сперма (sperma) – Үр гэсэн утгатай Грек үг.

зера (zera) – Үр, үр удам гэсэн утгатай Еврей үг